


- 800000 жилийн өмнө - НТӨ IV зуун монголын түүхийн аль үед хамаарах вэ?
A. Монголын эзэнт гүрэн
B. Монголын эртний улсууд
C. Монголын өвөг түүх
D. Монголын эзэнт гүрний дараах Монгол улс
- Монголын өвөг түүхийн үеийг ямар сурвалжид тулгуурлан сэргээн судалдаг вэ?
A. Бичгийн эх сурвалж
B. Эд өлгийн эх сурвалж
C. Дүрслэх эх сурвалж
D. Аман эх сурвалж
- Дүрслэх эх сурвалжийг ажиглан, тус олдвор эх сурвалжийн ямар төрөлд багтахыг тодорхойлно уу.



- Эд өлгийн
- Аман
- Цахим
- Бичгийн

- Он тооллын шугамыг ажиглан асуултад хариулна уу.


Он тооллын шугам-1



- Геологийн үечлэлээр уг үе нь хэдий үеээс эхлэх вэ?

- 3.5 сая жилийн өмнө
- 800000 жилийн өмнө
- 100000 жилийн өмнө
- 2.6 сая жилийн өмнө

- Доорх зурагт Архангай аймгийн Өндөр-Улаан сумын “Гол мод”- ны язгууртны булшнаас Ромын шилэн аяга гарсан юм. Энэ олдвор нь аль улсын язгууртны булшнаас гарсан бэ?



- Жужан
- Ром
- Түрэг
- Хүннү

- Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.
429 онд Умард улсын хаан Шизу хаан-г довтлохоор түшмэдтэйгээ зөвлөлдөхөд ихэнх түшмэл нь дайтах саналыг дэмжсэнгүй. Тэд хаанд дараах айлтгалыг өргөв. Айлтгасан нь: Энэ шаргачин могой гурван билгийн жил, Бархасбадь гариг, Сугар гараг өрнө зүг байна. Цэрэг хөдөлгөж умар зүг довтолж болохгүй, яалаа ч гэсэн Дээдэст золгүй болно.

- Муюн, Жужан
- Тоба, Жужан
- Хань, Хүннү
- Тан, Хүннү

- 12. Сурвалжид ямар хааны үйл хэргийг бичсэн байна вэ?**

A. Өгэдэй B. Хубилай C. Аригбөх D. Чингис

- 13.** Он тооллын шугамыг ажиглан асуултад хариулна уу.

Он тооллын шугам-2

ХМ

НТӨ

НТ

1 он

1248


1251

2025 он

Монголын эзэнт гүрний төрийн хэргийг хэн түр хамаарч байсан бэ?

- A. Түлүй В. Огүл Хаймиш С. Аригбөх D. Дөргэнэ

14. Түүхэн газар зүйн зурагт Монголын эзэнт гүрний аль бүрэлдэхүүн улсын нутаг дэвсгэр, хил хязгаарыг харуулсан болохыг тогтооно уу.



- A. Монголын Ил хаант улс
- B. Монголын Цагадайн улс
- C. Монголын Алтан ордон улс
- D. Монголын Их Юань улс

15. Бичгийн эх сурвалжийг уншиж, асуултад хариулна уу.

Сурвалж-2: “Тогоонтөмөр хааны гэмшил: -Тэндээс хаан Молташийн хаалгаар гаран буруулахдаа энэ мэт магтаж уйлан явав. Ерөнхийн эзэн хэмээгдсэн хайран их алдар нэр минь, Эрхэт сэцэн хааны байгуулсан эрдэнэ Дайду минь...”

1662 он Саган Сэцэний бичсэн “Эрдэнийн товч”-оос.

- Эрхэт сэцэн хаан гэж хэнийг хэлсэн бэ? Дайду нь одоогийн ямар хот вэ?
- A. Чингис, Хархорум хот
- B. Алтан хан, Хөх хот
- C. Хубилай, Бээжин хот
- D. Мөнх, Түмэн амгалант ордон

16. “Дөчин, Дөрвөн хоёрын” Монгол улс хэмээх түүхэн нэршилд “Дөрвөн” гэсэн нь ямар утга илэрхийлж байна вэ?

- A. Ордос, Түмэд, Еншээбү, Асудыг заана
- B. Дөрвөн түмэн Ойрад буюу баруун Монголыг заана
- C. Халх, Цахар, Урианхайн түмэнг заана
- D. Дөчин түмэн зүүн Монголыг заана

17. Эртний хүмүүс галыг хэдий үеээс эзэмшсэн бэ?

- A. Мезолит
- B. Дунд палеолит
- C. Неолит
- D. Дээд палеолит

18. Төмөр дөрөө аль улсын үед үүссэн бэ?

- A. Хятан
- B. Түрэг
- C. Хэрэйд
- D. Сяньби

19. Их, бага бичгийг (38 авиа бүхий) ямар улс хэрэглэж байсан бэ?

- A. Жужан
- B. Хятан
- C. Тоба вэй
- D. Хүннү

20. Монгол нутаг дахь эртний улсуудын эрхлэх гол аж ахуй юу вэ?

- A. Нүүдлийн мал аж ахуй
- B. Олзворлох аж ахуй
- C. Түүвэрлэх аж ахуй
- D. Газар тариалан, ан гөрөө

21. “Ертөнцөд ямар цэргийг монгол дайчидтай зүйрлэх билээ? Тэд нар дайны цагт ангийн сүрэг рүү архиран дайрагч арслан мэт, энхийн цагт сүү, ноос зэрэг ашиг шимээ өгөгч номхон хонь мэт ажгуу. Хэзээ ч өөр хоорондоо үл арсалдах энэхүү цэрэг дайчид нь дотроо бүх төрлийн мэргэжлийн хүмүүсээс бүрдэх тул ямар ч асуудал гарсан шийдэхгүй юм гэж үгүй бөгөөд хоол хүнс, хувцас хэрэглэл бэлтгэхэд үл сандарцаана. Монголчууд чухамдаа цэрэг болохоор заяагдсан мэт”.

Энэ нь ямар нэртэй эх сурвалж дээр бичигдсэн бэ?

- A. Монголын нууц товчоо
- B. Ибн Биби-гийн “Агуу үйл хэрэгт агуу удирдлага” зохиол
- C. Ата Малик Жувеинигийн “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх”
- D. Рашид ад-Дин “Судрын чуулган”

22. 1662 онд Саган Сэцэний бичсэн “Эрдэнийн товч”-д буй мэдээний гол санааг оновчтой тодорхойлно уу.

“...Ерөнхийн эзэн хэмээгдсэн хайран их алдар нэр минь, Эрхэт сэцэн (Хубилай) хааны байгуулсан эрдэнэ Дайду минь, Хувилгаан сэцэн хааны элдэвчлэн байгуулсан Дайту хот минь, Хумьж автвай хятадын Жүгэ ноёнд, Гутамшиг муу нэр Тогоонтөмөр надад ирэв хэмээн магтаж уйлсан ажгуу...”

- A. Тогоонтөмөр хаан төр улсаа алдаад гэмшсэн тухай
- B. Их Юань улс Дайду гэдэг хоттой байжээ
- C. Хубилай хаан төр улсаа алдаад гэмшсэн тухай
- D. Мин улсад Жүгэ нэртэй ноён байжээ

23. Сурвалжид гарч буй Усны гурван түмний эзэн гэж хэн бэ?

Сурвалж: “Цахарын хаан чиний илгээсэн бичигт Дөчин түмэн Монголын эзэн баатар Чингис хааны зарлиг. Усны гурван түмний эзэн Хүндлэн гэгээн хаанд бичиг илгээв! хэмээжүхүй...”

“Манжийн үнэн магад хууль”-аас.

- A. Занабазар
- B. Энх-Амгалан
- C. Лигдэн
- D. Нурхач

24. Адилтгах замаар бурханы шашны гол урсгалуудын нэршлийг тодорхойлно уу.

Шарын урсгал - Гэлүгва

Улааны урсгал - ?

- A. Манихейн
- B. Үнэн алдартан
- C. Нестор
- D. Гармава

25. Монголд бурхны шашин дэлгэрэхэд нөлөөлсөн гадаад хүчин зүйл юу вэ?

- A. Шашин дэлгэрэхэд улсаас эдийн засгийн дэмжлэг үзүүлсэн
- B. Улааны болон шарын урсгалууд Монголчуудаас цэрэг эдийн засгийн дэмжлэг хайсан
- C. Бөөгийн хойлголох ёсыг халж хүн нас барахад амьтны амь таслахыг хориглосон
- D. Шашны цаазаар лам нарын эрх дархыг хуульчлан баталж, дэмжих бодлого явуулсан
- E. Монголын эрх баригчид улс орныхоо нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлсэн